



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2018. 11. 22 № 04/3134  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Чиглэлийн дагуу ажиллан  
тайлан, мэдээг ирүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” 128 дугаар зарлиг, Монгол Улсын Их Хурлын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус хангаж ажиллах талаар салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах тухай чиглэл өгсөн.

Иймд уг чиглэлийн дагуу ажиллах буюу холбогдон гарсан албан бичгүүдийг салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдэд тараан 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор энэ чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, ажлын явцын мэдээллийг яаралтай ирүүлнэ үү.

Холбогдох хууль тогтоомжийн хуулбарыг хавсралтаар хүргүүлэв.  
Хавсралт З. хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ГУДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА   
М.БАЯРАА

1116127151  
УХА0580 9129294





МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮнд ҮЙЛДВЭРИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,  
<http://www.mmihi.gov.mn>

2018.11.19 № 01/3082  
танаи \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ  
АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД

Г Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах талаар салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдэд дараах чиглэлийг өгч байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгжүүд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2, 111.3 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх, үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулж ажиллах;

2. Аж ахуйн нэгжүүд орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байран дээр нь сурган дадлагажуулах замаар ажлын байраар хангаж ажиллах;

3. Салбар, орон нутгийн хэмжээнд ААН-үүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллах /үүнд: орох гарах гарцын шийдэл, мэдээллийн хүртээмж, нийгмийн харилцаанд тэгш оролцуулсан байдал, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх/;

4. Аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар ханган ажиллуулж байгаа талаарх мэдээлэл, тоо баримтыг үнэн зөв гаргаж тус яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор багтаан албан бичгээр ирүүлэх;

5. Зарлигийн хэрэгжилтийн талаар холбогдох газарт улирал бүр тайлاغнах тул аж ахуйн нэгжүүд чиглэлийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээ, үр дүнгийн талаарх тайлан, мэдээг /фото зураг хавсарган/ улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдөрт багтаан тус яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ үү.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 128 дугаар зарлигийн хуулбарыг хавсаргав.

Хавсралт..1.хуудастай.



Д.СҮМЬЯАБАЗАР



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 9 сарын 04 өдөр

Дугаар 128

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах асуудлаар Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2, 111.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад чиглэл болгох;

2. "Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолын хавсралтад хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилчдын 25 хүн тутамд 1 гэж, Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт сар бүр төлөх төлбөрийн хэмжээг тухайн байгууллагын ажиллагсдын дундаж цалингийн хэмжээгээр, бусад аймагт тухайн байгууллагын ажиллагсдын дундаж цалингийн 60 хувиар гэж тус тус тогтоон мөрдүүлэх;

3. Аж ахуйн нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бусад байгууллагуудын оролцоог тэгш хангасан Үндэсний хороог байгуулж, санд төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих дүрэм журмыг баталж мөрдүүлэх;

4. Энэ зарлигийн хэрэгжилтийн талаар 2018 оны намрын чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

Хоёр. Энэ зарлигийг 2018 оны 09 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХАЛТМААГИЙН БАТТУЛГА

УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ

ХУУЛБАР ҮНЭН

Тамгын газрын дэд дарга

Г.Байгалмаа

0000000501



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 46

Төрийн ордон, Улаанбаатар хот

### Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

1/"Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)"-ийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэмжийг амьжиргааны доод тувшиний хэмжээнд хүргэх, улсын төсвийн зарлагын ангилалд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг дэмжих зардлын ангиллыг шинээр нэмж тусгах;

3/цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, холбогдох тойротг байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог нарийвчлан гаргаж, тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэн ажиллах;

4/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвөөр дамжуулан хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах, зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;

5/бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж ажиллах;

6/улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн оношлоход шаардагдах оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж, тусгай хэрэгцээт сургуулийн зориулалтын тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын хүртээмжтэй материал, хэрэгсэл, сурагчдыг тээвэрлэх автобусаар хангах;

7/тусгай сургуульд ажиллаж байгаа багш, ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох, өрөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамааран хувьсах зардлыг нэмэгдүүлэх болон ажилласан жил, ур чадвар, ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулсан багш, ажилтан, албан хаагчдын цалин урамшууллын шинэ тогтолцоог бий болгох, зардлыг холбогдох төсөвт жил бүр тусгах;

8/тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах;

9/хөгжлийн бэрхшээлийг тогтоох олон улсын ангиллыг нэвтрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бурдүүлж, нийгмийн бүхий л үйлчилгээнд хамруулах;

10/хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг хөгжүүлэх төвүүдийг аймаг, дүүрэгт байгуулах;

11/хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд болон иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад хамран сургах, сургалтын ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах, сургалтын зардал болон тэтгэлгийг улсын төсвөөс олгох;

12/хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах;

13/хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, тэдгээрийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

14/тусгай хэрэгцээт боловсролын байгууллагад хүүхдийн тооноос хамааран туслах багш ажиллуулах, цалин, урамшууллыг жил бүрийн төсөвт тусгах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд, энэ тогтоолын биелэлтийн явцыг 2018 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ц.НЯМДОРЖ